



МОНГОЛБАНК



ГОЛОМТ БАНК

MNT/USD

ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН IV ЗӨВЛӨЛГӨӨН – 2011

Онцлох сэдэв:
ХАНШИЙН ЭРСДЭЛИЙН
УДИРДЛАГА

УЛААНБААТАР ХОТ
2011 ОНЫ 7-Р САРЫН 2

ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ
МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН
IV ЗӨВЛӨЛГӨӨН - 2011

Онцлох сэдэв: Ханшийн эрсдэлийн удирдлага



МОНГОЛБАНК

© 2011 оны 6-р сар, Монголбанк

Валют, эдийн засгийн газар, Санхүүгийн зах зээлийн хэлтэс

Бага тойруу 3, 15160.

Улаанбаатар, Монгол

Утас: 976-11-324149

Факс: 976-11-311471

Цахим хуудас: www.mongolbank.mn

Энэхүү товхимол нь Монголбанкны байр суурийг илэрхийлэхгүй бөгөөд аливаа үзэл санаа, дүгнэлт, тайлбар нь зөвхөн судлаачдад хамаарна.

Хэвлэлийн эх, нүүр хуудасны дизайн: Ш.Чулуунбаатар

АГУУЛГА

Валютын арилжааны мэргэжилтнүүдийн зөвлөлгөөний тухай	IV
Хөтөлбөр	1

Бүлэг I. Зохион байгуулагч байгууллагуудын товч танилцуулга 2

Монголбанк	2
Голомт банк	2

Бүлэг II. Илтгэгчдийн танилцуулга.....3

Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Н.Золжаргал	3
Монголбанкны Валют, эдийн засгийн газрын захирал Г.Дэлгэрмаа	3
Монголбанкны ВЭЗГ-ын Төлбөрийн тэнцлийн статистик, судалгааны хэлтсийн захирал С.Болд.....	4
Монголбанкны ВЭЗГ-ын Санхүүгийн зах зээлийн хэлтсийн ахлах эдийн засагч С.Ангарцэцэгб.....	4
Худалдаа хөгжлийн банкны Хөрөнгө зохицуулалтын газрын захирал Л.Гантөмөр.....	5
Голомт банкны Нөөцийн удирдлагын хэлтсийн валютын арилжааны мэргэжилтэн Б.Золбоо.....	5

Бүлэг III. Нээлтийн үг 6

Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Н.Золжаргал	6
--	---

Бүлэг IV. Илтгэл18

1.1 Банк хоорондын своп, форвард захыг хөгжүүлэх арга зам	18
1.2 Банк, харилцагч хоорондын своп, форвард хэлцлийн хэрэглээг идэвхижүүлэх нь.....	22
2.1 Монгол улс, БНХАУ-ын эдийн засгийн харилцаа, түүнд Монголбанк, Хятадын Ардын банк хооронд байгуулсан своп хэлцлийг ашиглах боломж.....	26
2.2 Юаний санхүүжилтын тухай	40

Бүлэг V. Оролцогчдын нэрс 47**Бүлэг VI. Зөвлөлгөөнөөс баталсан зөвлөмж..... 50**

ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ЗӨВЛӨЛГӨӨНИЙ ТУХАЙ

Монголбанк нь 2008 оноос валютын дотоодын захын үр ашгийг сайжруулах зорилгоор валютын захын оролцогчдын дунд “Валютын арилжааны мэргэжилтнүүдийн зөвлөлгөөн”-ийг жил бүр зохион байгуулсаар ирсэн билээ. Энэ жил “Ханшийн эрсдэлийн удирдлага” онцлох сэдэвтэйгээр 4 дэх удаагаа зохион байгуулж байна. Энэхүү дөрөвдүгээр зөвлөлгөөний зорилго нь санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг ашиглан ханшийн эрсдэлээс хамгаалах, Хятадын Ардын банктай байгуулсан своп хэлцлийн хэрэглээний талаар харилцан санал солилцох, нэгдсэн нэг ойлголттой болоход оршино.

ХӨТӨЛБӨР

Огноо:	2011 оны 7 дүгээр сарын 2-ны өдөр - Бямба гараг	
Хаана:	Corporate Resort, Нүхт	
Цаг:	09.40-14.30	
09:40-10:00	Оролцогчид болон зочдыг хүлээн авах	
НЭЭЛТИЙН АЖИЛЛАГАА		
10:00-10:20	Н.Золжаргал	Монголбанкны Дэд Ерөнхийлөгч
10:20-10:30	Жон Патрик Финиган	Голомт банкны Гүйцэтгэх захирал
ХЭЛЭЛЦҮҮЛЭГ 1. САНХҮҮГИЙН ҮҮСМЭЛ ХЭРЭГСЛҮҮДИЙГ АШИГЛАН ХАНШИЙН ЭРСДЭЛЭЭС ХАМГААЛАХ НЬ		
10:30-10:40 ИЛТГЭЛ 1.1	Банк хоорондын своп, форвард захыг хөгжүүлэх арга зам	
	Л.Гантөмөр	ХХБ-ны ХЗГ-ын захирал
10:40-10:50 ИЛТГЭЛ 1.2	Банк, харилцагч хоорондын своп, форвард хэлцлийн хэрэглээг идэвхижүүлэх нь	
	Б.Золбоо	Голомт банкны ХУГ-ын НУХ-ийн арилжааны мэргэжилтэн
10:50-11:20	Хэлэлцүүлэг	
Хэлэлцүүлгийн удирдагч:	С.Болд	Монголбанкны ВЭЗГ-ын ТТССХ-ийн захирал
Тэргүүлэгч гишүүд:	Ж.Батаа	Монголбанкны ВЭЗГ-ын СЗЗХ-ийн захирал
	Н.Батсайхан	Монголбанкны ЭУА-ны захирал
	М.Мөнхбаатар	УБХБ-ны ХЗГ-ын захирал
	С.Ганболд	Капитрон банкны ХУГ-ын захирал
11:20-11:50 ЗАВСАРЛАГА		
ХЭЛЭЛЦҮҮЛЭГ 2. ХЯТАДЫН АРДЫН БАНКТАЙ БАЙГУУЛСАН СВОП ХЭЛЦЛИЙН ХЭРЭГЛЭЭ		
11:50-12:10 ИЛТГЭЛ 2.1	Монгол улс, БНХАУ-ын эдийн засгийн харилцаа, түүнд Монголбанк, Хятадын Ардын банк хооронд байгуулсан своп хэлцлийг ашиглах боломж	
	Г.Дэлгэрмаа	Монголбанкны ВЭЗГ-ын захирал
12:10-12:20 ИЛТГЭЛ 2.2	Юанийн санхүүжилтын журмын төслийн танилцуулга	
	С.Ангарцэцэг	Монголбанкны ВЭЗГ-ын СЗЗХ-ийн ахлах эдийн засагч
12:20-12:50	Хэлэлцүүлэг	
Хэлэлцүүлгийн удирдагч:	Ж.Батаа	Монголбанкны ВЭЗГ-ын СЗЗХ-ийн захирал
Тэргүүлэгч гишүүд:	Г.Дэлгэрмаа	Монголбанкны ВЭЗГ-ын захирал
	Б.Мөнхбаатар	Голомт банкны ХУГ-ын НУХ-ийн захирал
	Л.Гантөмөр	ХХБ-ны ХЗГ-ын захирал
	Б.Эрдэнэдэлгэр	Хаан банкны ЭҮЗХ-ийн захирал
ХААЛТЫН АЖИЛЛАГАА		
12:50-13:00	Зөвлөлгөөнөөс гарсан зөвлөмжийг Монголбанкны ВЭЗГ-ын захирал Г.Дэлгэрмаа танилцуулна.	
13:00-14:30	ҮДИЙН ЗООГ	

I. ЗОХИОН БАЙГУУЛАГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



МОНГОЛБАНК

Монголбанк нь Монгол улсын хэмжээнд төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага бөгөөд үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангах ба энэ зорилтын хүрээнд санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Ерөнхийлөгч: Л. Пүрэвдорж

Валют, эдийн засгийн газар нь гадаад валютын улсын нөөцийн төлбөр түргэн гүйцэтгэх чадвар найдвартай байдлыг хангах, нөөцийг оновчтой байршуулах, гадаад худалдааны нөхцөл, төлбөрийн тэнцлийн байдалтай уялдуулан уян хатан валютын бодлого явуулах, дотоодын банк хоорондын валютын захыг хөгжүүлэх, олон улсын болон бүс нутгийн банк санхүүгийн байгууллага, гадаадын төв банк, банктai харьцах санрүүгийн зуучлал, үйлчилгээ, хүлээсэн үүргийн биелэлтийн найдвартай байдлыг хангах зорилгоор дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ.

1. Гадаад валютын зах зээлийн ерөнхий зохицуулалт
2. Гадаад валютын улсын нөөцийн өөрчлөлтийг тооцох, холбогдох судалгаа шинжилгээ хийх, нөөцийн удирдлага, зохицуулалтыг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах
3. Валютын ханшийн бодлогын үндэслэл боловсруулах, судалгаа хийх, хэрэгжүүлэх
4. Дотоодын валютын захын үйл ажиллагааг зохицуулах, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, дотоодын банкуудтай валютын арилжаа явуулах
5. Гадаад зээлийн төлбөр тооцоотой холбогдсон Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үйл ажиллагаа
6. Монголбанкнаас олон улсын болон бүс нутгийн банк санхүүгийн байгууллага, гадаадын төв банк, банктai харилцах санхүүгийн зуучлал, үйлчилгээ, хүлээсэн үүргийн биелэлтийн найдвартай байдлыг хангах
7. Төлбөрийн тэнцлийн гүйцэтгэл гаргах, валютын нөөцийн болон төлбөрийн тэнцлийн харилцан уялдааг хангахуйц бодлого боловсруулах
8. Улсын нөөцийг бүрдүүлэх зорилгоор дотоодын захаас алт, мөнгийг худалдан авч худалдах, олон улсын стандартад нийцүүлэн цэвэршүүлэх, шаардлагатай сорьцын хайлш бэлтгүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах



ГОЛОМТ БАНК

Голомт банк нь 1995 оны 3-р сарын 6-ний өдөр 4 ажилтан 436 сая төгрөгийн дүрмийн сантайгаар Соёлын Төв Өргөөний 3 давхарт анх үүсгэн байгуулагдаж үйл ажиллагаагаа эхлүүлж байсан түүхтэй. Тус банк нь "Бодь интернэшнл" группын Л.Болд, Д.Баясгалан, М.Зоригт нарын үүсгэн байгуулсан зуун хувь дотоодын хөрөнгө оруулалттай Монголын анхны хувийн банк юм.

Гүйцэтгэх захирал: Жон Патрик Финиган

Голомт банк нь байгуулагдсан цагаасаа эхлэн одоог хүртэл анхдагч тодотголтой алхмуудыг тогтмол хийж ирсэн бөгөөд дэлхийн санхүүгийн брэндүүдийг Монголын хөрсөнд буулгах их ажлыг хийж байна. Тухайлбал анхны "Голомт чек", анхны Мастеркарт карт, анхны Виза карт, анхны хувийн харилцах дансны үйлчилгээ, анхны дуудлагын банкны үйлчилгээ, анхны интернэт банкны үйлчилгээ, анхны хувийн банкны үйлчилгээ, анхны "24 цагийн үйлчилгээ", анхны улс хоорондын мөнгөн гуйвуулгын "Western Union" үйлчилгээ, анхны хөвөгч хүүтэй хадгаламж, анхны чөлөөт хөрвөх сертификат, анхны EMV чип карт, дансны орлого зарлагыг мессэжээр мэдээлэх үйлчилгээ, анхны хосолсон валют бүхий Dual Currency карт болон олон улсын зах зээлд дэх анхны China UnionPay юаний карт зэргийг нэрлэж болно.

Голомт банк нь олон улсын нэр хүнд бүхий 30 орчим банк санхүүгийн байгууллагатай нягт хамтран ажилладаг бөгөөд дэлхийд тэргүүлэгч Кредит Свисс банк болон Абу Дабигийн Хөрөнгө Оруулалтын Зөвлөл хоёрдогч өглөгийн зээлийн гэрээг тус банктai байгуулсан нь Монголын банк санхүүгийн салбарт гадны хөрөнгө оруулагчид хувь эзэмших сонирхолд суурилсан гэрээ байгуулсан анхны тохиолдол юм.

Голомт банк нь зээлийн эрсдэлийн үнэлгээгээр Монголбанкнаас тэг үнэлгээ авсан цор ганц банк бөгөөд үйл ажиллагааныхаа 16 дахь жилийн санхүүгийн үзүүлэлтээр арилжааны банкуудыг тэргүүлж Монголын хамгийн том банк болсон юм.

Ололт амжилтынхаа үндэс суурийг чадварлаг, мэргэжлийн ур чадвар бүхий, үнэнч шударга, бүтээмж өндөр ажилтнуудаа гэж үздэг тус банкны 1000 гаруй ажилтан албан хаагч нь 70 гаруй салбар тооцооны төвөөрөө дамжуулан санхүүгийн иж бүрэн үйлчилгээг чанарын өндөр түвшинд хүргэхийн төлөө хичээн ажиллаж байна.

II. ИЛТГЭГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА



Н.Золжаргал

Монголбанкны Дэд Ерөнхийлөгч

АЖЛЫН ТҮРШЛАГА

- 1988-1989 | Улсын банкны ерөнхий хороо, Гадаад тооцооны газар ня-бо
- 1989-1991 | Улсын банкны ерөнхий хороо, Гадаад тооцооны газар эдийн засагч
- 1991 | ХХБ, Гадаад харилцааны хэлтэст захирал
- 1991-1996 | Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал
- 1996-1997 | АНУ-ын Харвардын их сургуульд зөвлөх
- 1997-1998 | МУ-ын Ерөнхий сайдын зөвлөх
- 1998-2000 | Дэлхийн банк, KPMG компаний Бизнес менежментийн зөвлөх
- 2000-2007 | Хувийн сектор
- 2010 оноос Монголбанкны Дэд Ерөнхийлөгч

БОЛОВСРОЛ

- 1982-1988 | БНУУ-ын Будапешт хотын Эдийн засгийн их сургууль, Эдийн засгийн ухааны магистр
- 1995-1996 | АНУ-ын Харвардын их сургууль, Нийгмийн удирдлагын магистр



Г.Дэлгэрмаа

Валют, эдийн засгийн газрын захирал

Монголбанк

АЖЛЫН ТҮРШЛАГА

- 1995 – 1996 | Монголбанкны Хяналт шалгалтын газарт хянан шалгагч бөгөөд улсын байцаагч
- 1996 – 2000 | Монголбанкны Хяналт шалгалтын газрын Банкны үйл ажиллагааны хэлтсийн захирал
- 2000 – 2003 | ХААН Банкны Зээл хариуцсан дэд захирал бөгөөд Удирдлагийн багийн гишүүн, Монголбанкны томилолт, АНУ-ын USAID-ын Эдийн засгийн бодлогыг дэмжих төслийн урилгаар Хөдөө аж ахуйн банкны үйл ажиллагааг сэргээх, хувьчлалд бэлтгэх үүрэгтэй ажилласан
- 2003 – 2004 | Банк, санхүүгийн байгууллагуудад экспертийн болон үйл ажиллагааны зөвлөгөө өгөх үйлчилгээ эрхэлсэн. Энэ хугацаанд Улаанбаатар хотын банкны зөвлөхөөр ажиллаж байсан
- 2004 - 2005 | Хас банкны Үйл ажиллагаа эрхэлсэн орлогч захирал бөгөөд Удирдлагийн багийн гишүүн
- 2007/09 - 2008 | Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны Ерөнхийлөгчийн зөвлөх
- 2005 – 2008 | Банк, санхүүгийн байгууллагуудад зөвлөгөө өгөх, сургалт явуулах үйл ажиллагаа эрхэлдэг Нэүлэ ХХК-ийн Ерөнхий захирал
- 2008 оноос Монголбанкны Валют эдийн засгийн газрын захирал

БОЛОВСРОЛ

- 1991 – 1995 | Монгол Улсын Үндэсний Их Сургууль, Банкны эдийн засагч, бакалавр
- 1997 – 1998 | Япон улсын Сайтамагийн Бодлогын Шинжлэх Ухааны Их Сургууль, Төрийн бодлогын магистр
- 2003 – 2005 | Голланд улсын Мастрихтын Удирдлагын Ухааны Их Сургууль, Бизнесийн удирдлагын магистр



С.Болд

**Валют, эдийн засгийн газрын Төлбөрийн тэнцлийн статистик, судалгааны хэлтсийн захирал
Монголбанк**

АЖЛЫН ТҮРШЛАГА

- 2002-2003 | Эрдэнэт УҮГ, Металлын зах зээлийн шинжээч, эрсдэлийн удирдлага, гадаад худалдааны менежер
- 2004-2005 | АНУ-ын Мичиганы Технологийн Их Сургууль, Портфолио менежментийн төслийн багийн хөрөнгө оруулалтын шинжээч
- 2006 | Эрдэнэт УҮГ, Төслийн багийн судлаач
- 2006-2007 | Сангийн яам, Дэлхийн банкны ЕСТАС төсөл, Санхүүгийн шинжээч
- 2007 | Үйлдвэр, худалдааны яам, Хэлтсийн дарга
- 2007.12 | Монголбанкны Валют, эдийн засгийн газар, Судалгаа хариуцсан эдийн засагч
- 2009 оноос Монголбанкны Валют, эдийн засгийн газар, Төлбөрийн тэнцлийн статистик, судалгааны хэлтсийн захирал

БОЛОВСРОЛ

- 1998-2002 | МУШУТИС, Уул уурхайн инженер-эдийн засагч, Бакалавр
- 2003-2005 | АНУ-ын Мичиганы Технологийн Их Сургуулийн Бизнес, эдийн засгийн сургууль, Эрдэс баялгийн эдийн засагч, Магистр



С.Ангарצעэг

**Валют, эдийн засгийн газрын Санхүүгийн зах зээлийн хэлтсийн ахлах эдийн засагч
Монголбанк**

АЖЛЫН ТҮРШЛАГА

- 1995-1997 | Худалдаа хөгжлийн банк, Гадаад тооцооны газар, Нягтлан бодогч
- 1997-2002 | Худалдаа хөгжлийн банк, Гадаад тооцооны газар, Эдийн засагч
- 2002-2003 | Худалдаа хөгжлийн банк, Гадаад тооцооны газар, Ахлах эдийн засагч
- 2003-2005 | Худалдаа хөгжлийн банк, Харилцаа холбооны хэлтсийн захирал
- 2008 | Монголбанк, Валют, эдийн засгийн газрын арилжааны мэргэжилтэн
- 2008 оноос Монголбанк, Валют, эдийн засгийн газрын Санхүүгийн зах зээлийн хэлтсийн ахлах эдийн засагч

БОЛОВСРОЛ

- 1995 | ОХУ, Москва хотын "Удирдлагын академи", Олон улсын эдийн засгийн чиглэлээр магистр
- 2007 | Австрали улсын Мельбурны Их Сургууль, Бизнесийн удирдлагын магистр

СУРГАЛТ

- ОУВС-гийн сургалт: Санхүүгийн зах зээлийн шинжилгээ, Бүгд Найрамдах Австри Улс
- ОУВС-гийн сургалт: Санхүүгийн зах зээлийн шинжилгээ ба санхүүгийн үүсмэл хэрэгслүүд, Сингапур
- Бундесбанк: Санхүүгийн тогтвортой байдал, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН IV ЗӨВЛӨЛГӨӨН - 2011



Л.Гантөмөр

Хөрөнгө зохицуулалтын газрын захирал

Худалдаа хөгжлийн банк

АЖЛЫН ТҮРШЛАГА

- 2004 оноос Худалдаа хөгжлийн банкны Хөрөнгө зохицуулалтын газрын валютын арилжааны мэргэжилтэн, газрын захирлын орлогч, газрын захирал

БОЛОВСРОЛ

- 2000-2004 I Санхүү, эдийн засгийн дээд сургууль, Нягтлан бодогч– эдийн засагч, Бакалавр



Б.Золбоо

Хөрөнгө удирдлагын газрын Нөөцийн удирдлагын хэлтсийн валютын арилжааны мэргэжилтэн

Голомт банк

АЖЛЫН ТҮРШЛАГА

- 2006 оноос Голомт банкны Хөрөнгө удирдлагын газрын Нөөцийн удирдлагын хэлтсийн валютын арилжааны мэргэжилтэн

БОЛОВСРОЛ

- 2000 I АНУ, Оригон мужийн Гастон хотын ахлах сургууль
- 2006 I АНУ, Оригон мужийн Портланд хотын Портланд Стэйт Их Сургууль, Эдийн засагч, Бакалавр

III НЭЭЛТИЙН ҮГ. МОНГОЛБАНКНЫ ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЗОЛЖАРГАЛ

2011 оны 7 дугаар сарын 2-ны өдөр

Эрхэм хүндэт ноёд, хатагтай та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Валютын захын өнөөгийн байдал, тулгарч буй хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга зам, цаашдын хөгжлийн асуудлын талаар өөрсдийн санал бодлоо чөлөөтэй хуваалцан, зөвлөлдөхөөр “Валютын арилжааны мэргэжилтнүүдийн дөрөвдүгээр зөвлөгөөн”-д хүрэлцэн ирсэн эрхэм зочид, валютын захын мэргэжилтнүүд Та бүхэнд талархал илэрхийлье.

Өмнөх зөвлөлгөөнийг Хаан банкттай хамтран амжилттай зохион байгуулсан бөгөөд зөвлөлгөөний зөвлөмжийг ажил хэрэг болгох тал дээр Монголбанкнаас валютын захын оролцогчидтой нягт хамтран ажиллаж дараах ажлуудыг хийсэн байна. Үүнд:

Валютын захын оролцогчдын эрсдэлийн удирдлагыг сайжруулах чиглэлээр:

Валютын дотоодын захад нэмэлт санхүүгийн үйлчилгээ нэвтрүүлэх үүднээс “Валютын своп, форвард хэлцлийн гэрээ, заавар”-ыг боловсруулан баталж, 2010 оны 12 дугаар сарын 27-ний өдөр гадаад төлбөр тооцооны нэмэлт эрхтэй банкуудтай уг гэрээг байгуулсан бөгөөд нийт 64.0 сая ам.долларын болон төгрөгийн своп, форвард хэлцлийг 6 банкттай байгуулсан байна. Үүний үр дүнд төгрөгийн болон валютын зах нь мөнгөний бодлогод нийцтэйгээр ажиллах боломж бүрдэж, банкууд илүүдэл нөөцөө удирдах, спот захад үзүүлэх дарамт, ачааллыг тодорхой хэмжээгээр бууруулах, арилжааг хугацааны хувьд тархаан байршуулах, ханшийн хүлээлтийг бий болгох, банкны харилцагчийн хувьд ирээдүйн ам.долларын урсгалыг зохицуулах, ханшийн эрсдэлээс хамгаалах арга хэрэгсэлтэй болох боломжийг нээж өгсөн билээ. Манай улсын хувьд гадаад худалдааны эргэлт нэмэгдэхийн хэрээр дотоодын компаниудын валютын захад оролцох оролцоо улам нэмэгдэж байгаа бөгөөд гадаад худалдааны хэрэгцээгээ хангах зорилгоор валютын захад оролцож байгаа аж ахуйн нэгж байгууллагууд нь тодорхой хугацааны дараа валютын ханшийн эрсдэлээ удирдах үүднээс своп, форвард арилжааг харилцагч банкуудтай байгуулах хэрэгцээ, шаардлага улам нэмэгдэж байгаа ч банкуудаас харилцагч аж ахуйн нэгж байгууллагатай байгуулж буй своп, форвард хэлцлийн хэмжээ туйлын хангалтгүй байна.

Валютын арилжааны цахим систем, мэдээллийн нэгдсэн системийг бүрдүүлэх, валютын захын эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр:

Валютын дуудлага худалдааны программыг нэвтрүүлж, үйл ажиллагааг автоматжуулсан. Мөн банкуудад гадаад активаа найдвартай байршуулах, удирдах боломжийг олгох, гадаад валютын эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрт байдлыг хангах үүднээс “Дотоодын банкнаас Монголбанкинд гадаад валютын хадгаламж байршуулах журам, заавар”-ыг шинэчлэн боловсруулан баталлаа.

Валютын захын оролцогчдын чадавхи, мэргэшлийг дээшлүүлэх чиглэлээр:

Валютын дотоодын захын оролцогчдын чадавхи, мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор валютын своп, форвард хэлцлийн талаарх аж ахуйн нэгжид зориулсан танилцуулга сургалтыг “Barclays” банктай хамтран 2011 оны 3 дугаар сарын 4-ний өдөр зохион байгуулсан бөгөөд 80 гаруй аж ахуйн нэгж байгууллагын ажилтнууд оролцсон байна. Мөн МҮХАҮТ-тай хамтран “Эрсдэл түүнээс сэргийлэх, санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэрэглээ”-ний талаарх сургалтыг томоохон аж ахуйн нэгж байгууллагуудын 30 гаруй ажилтанд 6 сарын 3-ны өдөр зохион байгууллаа.

Цаашид валютын дотоодын захыг хөгжүүлэн бэхжүүлэх, түүнчлэн ханш, үнийн эрсдэлээс сэргийлэх санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг зах зээлд нэвтрүүлэх нь өнөөгийн бидний тулгамдсан гол асуудлуудын нэг хэвээр байсаар байна.

Монголбанк, Хятадын ардын банктай 5 тэрбум юань буюу 1 их наяд төгрөгийн дүн бүхий үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцлийн гэрээг 2011 оны 5 дугаар сарын 6-ны өдөр байгуулсан билээ. Энэхүү гэрээг байгуулснаар Монголбанк арилжааны банкуудын юаниар төлбөр түргэн гүйцэтгэх чадварт хүндрэл гарсан нөхцөлд захад юанийг шуурхай нийлүүлэх замаар гадаад валютын дотоодын захын тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх боломжтой болоод байна.

Түүнчлэн своп хэлцлийн гэрээнд гарын үсэг зурах ёслолын үеэр Монголбанк, Хятадын банкны Ерөнхийлөгч нар сүүлийн хоёр жилийн хугацаанд завсарлаад байсан Монгол Улс, БНХАУ-ын банк хоорондын тав дахь удаагийн дугуй ширээний уулзалтыг энэ жилдээ багтаан Улаанбаатар хотноо зохион байгуулахаар тохиролцсон. Уг дугуй ширээний уулзалтыг талууд хоёр улсын банк, санхүү, эдийн засгийн хамтын ажиллагаанд тулгамдаж буй бодлогын шинж чанартай асуудлуудыг хэлэлцэхээр удирдах албан тушаалтнуудыг оролцуулан зохион байгуулахаар болсон нь чухал ач холбогдолтой юм.

Иймд энэ удаагийн зөвлөлгөөний үеэр та бүхнийг Монгол Улс, БНХАУ-ын эдийн засаг, банк санхүүгийн хамтын ажиллагаанд тулгамдаж буй асуудлуудыг хөндөн хэлэлцэж, удахгүй Улаанбаатар хотноо зохион байгуулагдах дугуй ширээний уулзалтын үеэр хэлэлцэх асуудлуудыг тодорхойлох, бэлтгэл ажлыг хангахад дэмжлэг үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Эрхэм хүндэт зочид, валютын арилжааны мэргэжилтнүүд ээ,

Энэ удаагийн зөвлөлгөөн нь ханш, үнийн эрсдэлээс сэргийлэх арга замуудыг банкны болон нийт экспортлогч, импортлогчдын үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан, цаашдын хөгжлийн талаар хэлэлцсэн, бүтээлч, үр дүнтэй арга хэмжээ болно гэдэгт итгэлтэй байна.

Та бүгдийн илтгэл, хэлэлцүүлэгт амжилт хүсье!

**МОНГОЛБАНКНЫ ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЗОЛЖАРГАЛ:
МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ**



МОНГОЛБАНК

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Дэд ерөнхийлөгч
Н.Золжаргал


2011 ОНЫ 7ДУГААР САРЫН 2

Агуулга





ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ
ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ


- ✓ **ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ:** Эерэг хүлээлт
- ✓ **ГАДААД СЕКТОР:** Хөрөнгийн дотогшлох урсгал
- ✓ **МӨНГӨНИЙ СЕКТОР:** Инфляцийн болон бодит ханшийн чангарах дарамт
- ✓ **УЛСЫН ТӨСӨВ:** Тэлэлт ба хөрөнгө оруулалт
- ✓ **Эрсдэл ба Бодлогын сорилтууд**
- ✓ **Дүгнэлт**









12 МОНГОЛБАНКНЫ ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЗОЛЖАРГАЛ:
МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ








Ханшийн бодлого

- Уян хатан ханшийн дэглэм**
 Макро эдийн засгийн нөхцөлүүдтэй уялдан бодитой, чөлөөтэй тогтох ханш
- Монголбанкны интервенци**
 Ханшийн огцом өөрчлөлтийг зөөлрүүлэх чиглэлээр оролцох


Монголбанкны зарласан ханш: Тогтвортой → 2009 оны 4 дүгээр сараас



Эх сурвалж: Монголбанк

15

Инфляци: 4 дүгээр сарын эцсийн байдлаар 5.5% → Удирдах боломжтой



Эх сурвалж: Монголбанк

17



Эрсдэл ба Бодлогын сорилтууд

- Эдийн засгийн халах дарамт? Эсвэл сэргэлт?
- Инфляцийн дарамт (Хэчнээн нь дотоодод бий болж байна вэ?)
- Гадаад секторын эмзэг байдал (Богино хугацаа)
- Халуун мөнгөний урсгал? (Стерилизаци хийх хэмжээ?)



Дүгнэлт

**Хөрөнгийн дотогшлох урсгалын нөлөөгөөр ханшид
үзүүлж буй нөлөө, хэлбэлзлийг хэрхэн
зохицуулж, удирдах вэ ?**

- Банк хоорондын своп, форвард захыг хөгжүүлэх
- Банк, харилцагч хоорондын своп, форвард хэлцлийн хэрэглээг идэвхижүүлэх
- Хятадын ардын банктай байгуулсан своп хэлцлийг ашиглах боломж

21

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ 1. САНХҮҮГИЙН ҮҮСМЭЛ ХЭРЭГСЛҮҮДИЙГ АШИГЛАН ХАНШИЙН ЭРСДЭЛЭЭС ХАМГААЛАХ НЬ

ИЛТГЭЛ 1.1 БАНК ХООРОНДЫН СВОП, ФОРВАРД ХЭЛЦЛИЙН ЗАХЫГ ХӨГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ

Илтгэгч: Л.Гантөмөр

Худалдаа хөгжлийн банкны Хөрөнгө зохицуулалтын газрын захирал



- Банк хоорондын своп, форвард хэлцлийн өнөөгийн байдал
- Тулгарч буй бэрхшээлүүд
- Хөгжүүлэх боломжууд
- Гарах үр дүн



Өнөөгийн байдал

Одоогийн байдлаар тус зах зээлд Монголбанкнаас гадна дараах зөвшөөрөл авсан арилжааны банкууд оролцож байна.

Худалдаа Хөгжлийн Банк

Голомт Банк

ХААН Банк

Хадгаламж Банк

Хас Банк

Капитал Банк

Төрийн Банк*



Өнөөгийн байдал

2010 оны сүүлээр Монголбанк санаачлага гаргаснаар валютын своп, форвард арилжааны ерөнхий гэрээг банкуудын хооронд байгуулсан. Үүнээс хойш доорх хэмжээний арилжаа хийгдээд байна.

1. Монголбанк, арилжааны банкны хооронд хийгдсэн своп, форвард хэлцэл:

Своп хэлцэл- 14.0 сая ам.доллар

Форвард хэлцэл- 50.0 сая ам.доллар

2. Банк хооронд хийгдсэн своп, форвард хэлцэл:

Своп хэлцэл- 46.0 сая ам.доллар



Тулгарч буй бэлхшээлүүд

- Мөнгөний захын хүүгийн түвшин тодорхой бус байна
- Тодорхой бус байдал – Монголбанк арилжааны банкуудтай арилжаа хийх нь тогтмол биш байгаа
- Зах зээлд оролцогчид цөөн
- Банкууд хоорондоо лимит байхгүй байгаа



Хөгжүүлэх боломжууд

- Зах зээлд оролцогчдыг нэмэгдүүлэх
- Төгрөгийн бенчмарк хүүг бодитой болгох /UBIBOR/
- Арилжааны банк хоорондын хэлцлийн стандарттай болох
- Банкууд нь хоорондоо идэвхитэй арилжаа хийхэд дэмжлэг үзүүлэх /Монголбанк зуучлагчаар оролцох/
- Банкуудын хэджинг хийх сонирхол нэмэгдэж байгаа



Гарах үр дүн

Банкуудын богино хугацааны төлбөр түргэн гүйцэтгэх чадвар

Валютын ханшийн эрсдэлээс хамгаалах хэрэгсэл нэмэгдэнэ

Банкны системийн эрүүл байдал бий болно

Банкуудын итгэлцэл нэмэгдэнэ

Арилжааны нэгдсэн стандарттай болно




Анхаарал тавьсанд баярлалаа.



ИЛТГЭЛ 1.2 БАНК, ХАРИЛЦАГЧ ХООРОНДЫН ФОРВАРД АРИЛЖАА

Илтгэгч: Б.Золбоо

Голомт банкны Хөрөнгө удирдлагын газрын Нөөцийн удирдлагын хэлтсийн валютын арилжааны мэргэжилтэн



Форвард арилжааны зорилго:

- ❖ Ханшийн хэлбэлзэл 2011 оны эхний хагаст 7.3% байсан.



GOLOMT BANK

Форвард арилжааны зорилго:

- ❖ Гадаад худалдааны тэнцэлийн алдагдал 2011 оны 5 сарын байдлаар өнгөрсөн оны мөн үеийнхээс 8 дахин өссөн;
- ❖ Гадаад худалдааны тэнцэл 2011 оны 5 сарын байдлаар, /сая ам.доллараар/

Экспорт	Жилийн өөрчлөлт %	Импорт	Жилийн өөрчлөлт %	Худалдааны тэнцэл	Жилийн өөрчлөлт %
1,578.0	59.4%	2,117.6	101.7%	-539.5	796.2%

GOLOMT BANK

4

Форвард арилжаа одоогийн байдлаар:

- ❖ Форвард арилжааг зах зээлд нэвтрүүлэх
 - ✓ Гадаад валют худалдан авагч худалдагч хоёрын хооронд зуучлах;
 - ✓ Хүүн дээр тулгуурласан сонгодог аргаар хийх;
- ❖ Дараах валютын хосууд дээр форвард хэлцэл хийж болно
 - ✓ Ам.доллар ба төгрөг;
 - ✓ Кросс валютын хосууд;
 - ✓ Төгрөг ба бусад валют;

 GOLOMT BANK

Форвард хэлцэлийн онцлог:

- ❖ Биржээр арилжаалагддаггүй;
- ❖ Хоёр тал доорх нөхцлүүдийг тохиролцож болно;
 - ✓ Ханш
 - ✓ Тухайн хоёр валютын хүү
 - ✓ Хугацаа
 - ✓ Дүн
 - ✓ Барьцаа

 GOLOMT BANK

6

Форвард хэлцэл хийхэд анхаарах зүйлс:

- ❖ Тайлан баланст ханшийн тэгшитгэлийн бодит бус орлого зарлагыг тусгах;
- ❖ Нарийн тооцсон мөнгөн урсгал дээр үндэслэж хэлцэл хийх;
- ❖ Форвард арилжааны дүн, хугацаа болон зах зээлийн байдлаас шалтгаалан барьцаа байршуулах;
- ❖ Арилжаа нь бодит төлбөрийн зориулалттай байх;

Анхаарал тавьсанд баярлалаа



ХЭЛЭЛЦҮҮЛЭГ 2. ХЯТАДЫН АРДЫН БАНКТАЙ БАЙГУУЛСАН СВОП ХЭЛЦЛИЙН ХЭРЭГЛЭЭ

ИЛТГЭЛ 2.1 МОНГОЛ УЛС, БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦАА, ТҮҮНД МОНГОЛБАНК, ХЯТАДЫН АРДЫН БАНК ХООРОНД БАЙГУУЛСАН СВОП ХЭЛЦЛИЙГ АШИГЛАХ БОЛОМЖ

Илтгэгч: Г.Дэлгэрмаа

Монголбанкны Валют, эдийн засгийн газрын захирал

	Валют арилжааны мэргэжилтнүүдийн IV зөвлөлгөөн
1	МОНГОЛ УЛС, БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦАА, ТҮҮНД МОНГОЛБАНК, ХЯТАДЫН АРДЫН БАНК ХООРОНД БАЙГУУЛСАН СВОП ХЭЛЦЛИЙГ АШИГЛАХ БОЛОМЖ
Г.Дэлгэрмаа	Монголбанкны Валют, эдийн засгийн газрын захирал
	www.mongolbank.mn

АГУУЛГА	
□ Монгол Улс, БНХАУ-ын эдийн засгийн харилцаа i. Гадаад худалдаа ii. Валютын урсгал iii. Хөрөнгө оруулалт □ Монголбанк, Хятадын ардын банк хооронд байгуулсан своп хэлцлийн ач холбогдол i. Юань: Олон улсын валют? ii. Юаний Монгол Улсын эдийн засагт үзүүлэх нөлөө ба своп хэлцлийн ач холбогдол □ Монгол, Хятадын банк хоорондын V удаагийн дугуй ширээний уулзалт i. Зорилго ба онцлог ii. Оролцогчид iii. Хэлэлцэх асуудлууд	


3



1. МОНГОЛ УЛС, БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦАА



МОНГОЛ УЛС, БНХАУ-ЫН ГАДААД ХУДАЛДАА

❖ Экспорт






Монгол Улс, БНХАУ-ын гадаад худалдаа


❖ Импортын бүтэц (2011 оны эхний 05 сар)

Голлох 18 бүтээгдэхүүний ангилал	Дүн	Тухайн бүтээгдэхүүний нийт импортод эзлэх хувь (%)
1 Ачааны автомашин	118,112	53.0%
2 Бульдозер, эксковатор зэрэг хүнд машин	24,593	19.8%
3 Трансформатор, цахилгаан үүсгүүр	19,754	75.9%
4 Шороо, чулуу ялгах төхөөрөмж	17,466	23.8%
5 Ган хоолой, ширээсгүй хөндий ган огтолбор	12,177	88.1%
6 Мотоцикл, дугуйт тэрэг	10,826	98.9%
7 Хүнд механизмын эд анги	10,180	27.9%
8 Шинэ дугуй	7,333	26.6%
9 Телевизор	7,178	34.3%
10 Компьютер, түүний эд анги	6,342	36.3%
11 Шингэн зүйлсийн насос	6,202	51.0%
12 Мебель ба түүний эд анги	5,327	57.3%
13 Хөргөх төхөөрөмж	5,321	64.0%
14 Телефон, цахилгаан аппарат	5,266	42.7%
15 Шугаман хоолой уурын тогоо	4,989	67.4%
16 Боодлын хуванцар хайрцаг, сав	4,975	81.3%
17 Шүүх, ялгах төхөөрөмж	4,057	27.0%
18 Агаар сорох насос	3,390	54.0%
19 Ачаа өргөх, буулгах төхөөрөмж	2,823	42.8%
20 Хэвлэгч машин, түүний эд анги	2,057	32.4%
Голлох 20 бүтээгдэхүүний импорт, БНХАУ-аас (1)	278,366	
БНХАУ-аас импортлосон бүтээгдэхүүний дүн	645,953	
Монгол улсын нийт импорт	2,117,576	

Монгол Улс, БНХАУ-ын гадаад худалдаа


❖ 2011 оны төсөөлөл






МОНГОЛ УЛС, БНХАУ-ЫН ВАЛЮТЫН УРСГАЛ

❖ БНХАУ-тай хийж буй төлбөр тооцоонд юанийн эзлэх хувь



МОНГОЛ УЛС, БНХАУ-ЫН ВАЛЮТЫН УРСГАЛ

❖ Юанийн орох урсгал (2011 оны 1 дүгээр улирал)







15


Юань: Олон улсын валют?

■ Олон улсын валют гэж:

- I. Олон улсын төлбөр тооцоонд түлхүү ашиглагддаг байх
- II. Нөөцийн валют болох
- III. Чөлөөтэй хөрвөдөг байх

■ Юанийг олон улсын валют болоход шаардагдах өөрчлөлт

- I. Хөрөнгө, санхүүгийн дансыг чөлөөтэй болгох
- II. Ханшийг чөлөөлж, зах зээлийн зарчимд нийцүүлэх
- III. Хүүг чөлөөлж, зах зээлийн зарчимд нийцүүлэх






Юань: Олон улсын валют?

17

- **Юань хил хоорондын төлбөр тооцоонд ашиглагдаж байгаа байдал /тэрбум юаниар/:**



Юань: Олон улсын валют?

18

- **Төв банкууд ХАБ-тай своп хийх замаар юаний хэрэглээг нэмэгдүүлэх хандлагатай байна /тэрбум юаниар/:**

Төв банкууд	Огноо	Хэмжээ
1 Bank of Korea	12/12/2008	180
2 Hong Kong Monetary Authority	1/20/2009	200
3 Bank Negara Malaysia	2/8/2009	80
4 National Bank of the Republic of Belarus	3/11/2009	20
5 Bank Indonesia	3/23/2009	100
6 Central Bank of Argentina	4/2/2009	70
7 Central Bank of Iceland	6/9/2010	3.5
8 Monetary Authority of Singapore	7/23/2010	150
9 Reserve Bank of New Zealand	4/18/2011	25
10 Central Bank of Uzbekistan	4/19/2011	0.7
11 Bank of Mongolia	5/6/2011	5
12 National Bank of Kazakhstan	6/13/2011	7
		841.20





 **Юань: Олон улсын валют?**

22

□ **Юаний хүү зах зээлийн зарчмаар тогтох орчин бүрэлдэж байна:**

Төрөл	Хүүг чөлөөтэй болгох алхмууд
Гадаад валютын хүү	2003 онд бүрэн чөлөөлсөн
SHIBOR	2007 оноос зах зээл SHIBOR-ыг тогтоох болсон
Хувийн хэвшлийн үнэт цаас /бонд/	2009 оноос зах зээлийн зарчмаар үнэлгээ хийгддэг болсон
Моргейжийн хүү	2008 оноос моргейжийн хөвөгч хүүгийн дээд, доод хязгаарыг нэмэгдүүлсэн
Зээл/хадгаламжийн хүү	Зээлийн хүүгийн доод хэмжээ болон хадгаламжийн хүүгийн дээд хэмжээг зааж өгч байгаа. Үүнийг багасгах хандлагатай байна.



23

Юань: Монгол Улсад?

□ Юань олон улсын валют болох хэрээр:

- I. Юаний бусад валют чөлөөтэй хөрвүүлэх, худалдан авах
- II. Юаний ханш чангарах
- III. Юаний гадаад төлбөр тооцоо, дотоодын захад эзлэх хувь өсөх
- IV. **Юаниар төлбөр тооцоо гүйцэтгэх!!!**

□ Монголбанк, ХАБ-нд байгуулсан своп хэлцлийн гэрээ нь:

- I. Гадаад худалдааг дэмжих
- II. Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах
- III. Үндэсний мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлыг хангах

24

3. Монгол, Хятадын банк хоорондын V удаагийн дугуй ширээний уулзалт





Дугуй ширээний уулзалтын зорилго

25

- **Зорилго**
 - Хил худалдааны төлбөр тооцооны тулгамдсан асуудлуудыг хэлэлцэх
 - Банк, санхүүгийн байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх
- **Энэ удаагийн уулзалтын онцлог**
 - Бодлогын түвшний асуудлуудыг хэлэлцэх
 - Удирдах албан тушаалтнууд оролцох
 - Өргөн хүрээгээр зохион байгуулах



Оролцогчид

26

- **Оролцох байгууллагууд**
 - Төв банкууд /**бодлого гаргагч, удирдах албан тушаалтнууд**/
 - Холбогдох яамд /**СЯ, ЭБЭХЯ, ЗТХБЯ**/
 - **Гаалийн байгууллагууд**
 - Арилжааны банкууд
 - Хөрөнгө оруулагчид /**CDB, CIC, China Exim Bank**/
 - **Аж ахуйн нэгжүүд**



Хэлэлцэх асуудлууд

27

□ Тулгамдаж буй асуудлууд

- Монгол, Хятадын банк хооронд хийгдэх валютын арилжаа
- Бэлэн юаний зузаатгал

□ Бусад хэлэлцэх шаардлагатай асуудлууд

- Төрийн байгууллагуудын саналыг авах
- Банкуудын саналыг авах
- Аж ахуйн нэгжүүдийн саналыг авах

Анхаарал тавьсанд баярлалаа!

28

ИЛТГЭЛ 2.2 ЮАНИЙ САНХҮҮЖИЛТЫН ТУХАЙ

Илтгэгч: С.Ангарцэцэг

Монголбанкны Валют, эдийн засгийн газрын Санхүүгийн зах зээлийн хэлтсийн ахлах эдийн засагч

	Валют арилжааны мэргэжилтнүүдийн IV зөвлөлгөөн
1	ЮАНИЙ САНХҮҮЖИЛТЫН ТУХАЙ
С.Ангарцэцэг	Монголбанкны Валют, эдийн засгийн газрын ахлах эдийн засагч www.mongolbank.mn

	Агуулга
2	❑ Монголбанк, Хятадын ардын банк хооронд байгуулсан своп хэлцлийн тухай I. Своп хэлцлийн ач холбогдол II. Своп хэлцлийн ерөнхий нөхцөл III. Своп хэлцэл хэрхэн явагдах талаар ❑ Юаний эх үүсвэрийг банкуудад олгох арга замууд I. Монголбанкнаас баримтлах зарчим II. Юаний санхүүжилт олгох хэрэгслүүд

3

1. СВОП ХЭЛЦЛИЙН ТУХАЙ



4

Своп хэлцлийн ач холбогдол

□ Ач холбогдол

- I. Юаниар төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах
- II. Дотоодын валютын захын тогтвортой байдлыг хангах
- III. Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн тогтвортой байдлыг хангах

□ Зориулалт

- I. Хоёр орны хоорондын худалдааг санхүүжүүлэх
- II. Санхүүгийн зах зээлийг тогтвортой байдлыг хангах
- III. Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн тогтвортой байдлыг хангах



Своп хэлцлийн нөхцөл

5

1. Своп хэлцлийн хугацаа, мөнгөн дүн

Гэрээ: 3 жил

Хэлцэл: 6 сар хүртэл /хэлцлийг сунгах боломжтой/

Хэмжээ: 5 тэрбум юань буюу 1 их наяд төгрөг


1. Своп хэлцлийн хүү, ханш


Юаний хүү: SHIBOR-т тулгуурлана

Төгрөгийн хүү: Банк хоорондын хэлцлийн жигнэсэн дундаж хүү

Юаний ханш: ХАБ-ны CFETS-гийн ам.долларын ханш


Төгрөгийн ханш: Монголбанкны ам.долларын албан ханш





7

II. Юаний эх үүсвэрийг банкуудад олгох хувилбарууд



8

Юаний эх үүсвэрийг банкуудад

□ Монголбанк юаний эх үүсвэрийг банкуудад олгоход дараахь зарчмуудыг баримтална:

- Ханшийн эрсдэл хүлээхгүй байх
- Хүүгийн эрсдэл хүлээхгүй байх
- Зах зээлийн зарчмаар явагдах
- Мөнгөний бодлогод харшлахгүй байх



Юаний эх үүсвэрийг банкуудад

9

□ Юаний эх үүсвэрийг олгох боломжит хувилбарууд:

- Юанийг банкуудад худалдах
- Юаниар банкуудад зээл олгох
- Юань төгрөгийн своп хэлцэл хийх
- Юаний репо хэлцэл хийх /санхүүгийн хэрэгслүүдийн эсрэг/

□ Юаний санхүүжилт:

- Байнгын хэрэгсэл
- Онцгой нөхцөлд
- Тогтмол хуваарийн дагуу



Юаний эх үүсвэрийг банкуудад

10

□ Юанийг банкуудад зээлээр олгох:

- Төв банк гадаад валютаар зээл банкуудад олгох зохимтой эсэх
- Мөнгөний бодлогод харшлах эсэх

□ Юаний эх үүсвэрт:

- SHIBOR+ 2.5%-аас багагүй



Юаний эх үүсвэрийг банкуудад

11

- Юанийг банкуудтай **своп** хэлцэл хийх замаар олгох:
 - Юаний эх үүсвэрт: SHIBOR+ 2.5%-аас багагүй
 - Төгрөгийн эх үүсвэрт: ???



Юаний эх үүсвэрийг банкуудад

12

- Юанийг банкуудтай **репо** хэлцэл хийх замаар олгох:
 - Юаний эх үүсвэрт: SHIBOR+ 2.5%-аас багагүй
 - Барьцаа хөрөнгө: ТБҮЦ?
 - Барьцаа хөрөнгөнд тооцох haircut: ???

V. ОРОЛЦОГЧДЫН НЭРС

БАЙГУУЛЛАГА	ХҮНИЙ ТОО	НЭРС	ГАЗАР, ХЭЛТЭС	АЛБАН ТУШААЛ
Олон улсын байгууллага	2			
Азийн хөгжлийн банк	2	Б.Анар		Захиргааны туслах
		Б.Индраа		Захиргааны туслах
Төрийн байгууллага	1			
Санхүүгийн зохицуулах хороо, Бичил санхүүгийн газар	1	Ш.Эрдэнэцэцэг	Бичил санхүүгийн газар	Ахлах хянан шалгагч, улсын байцаагч
Арилжааны банкууд	37			
Голомт	2	Б.Мөнхбаатар	НУХ	Захирал
		Б.Золбоо	НУХ	Дилер
ХХБ	7	Л.Гантөмөр	ХЗГ	Захирал
		Б.Батдэлгэр	АХ	Дилер
		Д.Мөнхбат	АХ	Дилер
		Б.Мөнхдэлгэр	ХЗГ	Дилер
		М.Анар	АХ	Дилер
		Д.Оч	ХЗГ	Дилер
		Т.Даваажав	ТДБ капитал	Захирал
ҮХОБ	2	Т.Уянга		Гадаад харилцааны ажилтан
		З.Мөнхзаяа		Санхүү тайлан бүртгэлийн газрын захирал
ТХБ	1	Б.Энхтүвшин	НГ	
Хас	2	Ц.Банзрагч	ХЗХ	Захирал
		Н.Эрдэм	ХЗХ	Дилер
Капитрон	2	С.Ганболд	ХУГ	Захирал
		М.Мэргэнбаатар	ХУГ	Дилер
Хадгаламж	3	Б.Өлзийбаяр	ХЗХ	Захирал
		Г.Батжаргал	ХЗХ	Ахлах дилер
		П.Нямбаяр	ХЗХ	Дилер
Төрийн банк	2	Ж.Гаваа	ХЗА	Менежир
		Л.Тамир	ХЗА	Дилер
Чингис хаан	2	А.Батжаргал	ХЗТХ	Захирал
		Ү.Билгүүн	ХЗТХ	Дилер
Кредит банк	1	Р.Туяа		Шинжээч
УБХБ	2	М.Мөнхбаатар	ХЗГ	Захирал
		А.Баторгил	ХЗГ	Ахлах дилер
Хаан	6	Б.Эрдэнэдэлгэр	ЭҮЗХ	Хэлтсийн дарга
		Д.Пүрэвгэрэл	ЭҮЗХ	Ахлах дилер
		Т.Ууганбаяр	ЭҮЗХ	Дилер
		Э.Зэс-эрдэнэ	ЭҮЗХ	Дилер
		Г.Ганчимэг	ЭҮЗХ	Дилер
		Т.Хонгорзул	ЭҮЗХ	Эдийн засагч

48 ОРОЛЦОГЧДЫН НЭРС

Капитал	3	А.Энхжаргал	СУ	Газрын захирал
		Л.Энхтайван	ХЗА	Дилер
		Х.Мандах	ХЗА	Дилер
Эрэл	2	М.Ууганчимэг		ГТТ-ны ажилтан
		Ж.Гэлэгжамц		Эрсдэлийн менежер
Монголбанк	28			
Дэд ерөнхийлөгч	1	Н.Золжаргал		
Валют, эдийн засгийн газар	19	Г.Дэлгэрмаа	ВЭЗГ	Захирал
		Ж.Батаа	Санхүүгийн зах зээлийн хэлтэс	Захирал
		С.Ангарцэцэг	СЗЗХ	Ахлах эдийн засагч
		Э.Идэр	СЗЗХ	Нөөцийн мэргэжилтэн
		Э.Анар	СЗЗХ	Дадлагажигч ажилтан
		О.Одгэрэл	СЗЗХ	Эдийн засагч
		Ш.Чулуунбаатар	СЗЗХ	Дадлагажигч ажилтан
		Б.Энхдалай	СЗЗХ	Дадлагажигч ажилтан
		С.Болд	Төлбөрийн тэнцлийн статистик, судалгааны хэлтэс	Захирал
		Ц.Мөнхбаяр	ТТССХ	Ахлах эдийн засагч
		А.Чингүнжав	ТТССХ	Эдийн засагч
		О.Отгонтөгс	ТТССХ	Эдийн засагч
		Г.Дулмаа	ТТССХ	Эдийн засагч
		Э.Амаржаргал	ТТССХ	Эдийн засагч
		Т.Энэрэл	ТТССХ	Эдийн засагч
		А.Цолмон	ТТССХ	Эдийн засагч
		Ц.Бямбацогт	ТТССХ	Эдийн засагч
		Г.Өсөхбаяр	ТТССХ	Дадлагажигч ажилтан
		С.Мөнхчимэг	ТТССХ	Дадлагажигч ажилтан
Мөнгөний бодлого, судалгааны газар	2	Д.Болдбаатар	МБСГ	Захирал
		Р.Саранцэцэг	МБХ	Захирал
Төлбөр тооцоо, бүртгэлийн газар	1	Д.Намжилсүрэн	Бүртгэлийн хэлтэс	Захирал
Хяналт шалгалтын газар	1	Б.Лхагвасүрэн	ХШГ	Захирал
Эрсдлийн удирдлагын алба	1	Н.Батсайхан	ЭУА	Захирал
Хуулийн хэлтэс	1	Г.Эрдэнэбаяр	ХХ	Захирал
Тамгын газар	1	Г.Цэрэнпүрэв	ТГ	Захирал
Дотоод аудитын газар	1	С.Ганбаяр	ДАГ	Ахлах хянан шалгагч
Нийт оролцогчдын тоо	68			

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУД

1	Жем Интернэшнл ХХК	25	Номин Холдинг ХХК
2	Харанга Ресурс	26	Номун кондитер
3	Хүннү Ресурс	27	Оюуны ундраа
4	Айвенхоу Майнз	28	Оюутолгой
5	Лэйтон	29	Скайтэл ХХК
6	МонЕнКо	30	СЭЭКЛ ХХК
7	Өмнийн Говийн Элс ХХК	31	Таван Толгой Транс ХХК
8	НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөр, Монгол	32	Таван толгой ХК
9	Вагнер Ази ХХК	33	Тайж Трейд ХХК
10	Болдтөмөр Ерөө Гол ХХК	34	Шунхлай ХХК
11	БСИЖМН ХХК	35	Эм Си Эс ХХК
12	Жи-Мобайл	36	Эм Эс Эм ХХК
13	Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр Тө ХК	37	Энержи Ресурс ХХК
14	ИНЕГазар	38	Эрдэнэт Үйлдвэр
15	Ирмүүн ХХК	39	Эйч энд эйч ХХК
16	Магнай Трейд ХХК	40	Юнитэл ХХК
17	МИАТ	41	
18	Мобиком ХХК	42	
19	Монголросцветмет ХХК	43	
20	Монголын Алт (МАК ХХК)	44	
21	Моннис Интернэшнл ХХК	45	
22	Намуун Инттертрейд ХХК	46	
23	Наран ХХК	47	
24	НИК ХК, Петровис ХХК	48	

ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ЭЭЛЖИТ ДӨРӨВДҮГЭЭР ЗӨВЛӨЛГӨӨНИЙ ҮР ДҮН, ЗӨВЛӨЛГӨӨНӨӨС БАТАЛСАН ЗӨВЛӨМЖ

Монголбанк нь валютын арилжааны мэргэжилтнүүдийн ээлжит дөрөвдүгээр зөвлөлгөөнийг 2011 оны 7 дугаар сарын 2-ны өдөр Нүхт цогцолборын Корпорейт ресортод Голомт банктai хамтран амжилттай зохион байгууллаа. Зөвлөлгөөнд банк, гадаад худалдаа эрхэлдэг томоохон аж ахуйн нэгжүүд, төрийн болон олон улсын байгууллагын төлөөлөл, мэргэжилтнүүд зэрэг нийт 100 гаруй зочид оролцож, санал бодлоо нээлттэй, чөлөөтэй илэрхийлэв.

Зөвлөлгөөний үр дүнд үндэслэн валютын дотоодын зах зээлийг хөгжүүлэх, түүний үр ашгийг сайжруулах, ханшийн эрсдэлээс сэргийлэх чиглэлээр Монголбанк, банк, ББСБ, төрийн байгууллага, аж ахуйн нэгжид дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна:

◇ Монголбанк:

- Монголбанк, Хятадын ардын банк хооронд байгуулсан үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцлийн гэрээний юанийн эх үүсвэрийг банкуудад олгох үйл ажиллагааны эрх зүйн орчныг зохицуулах журам, зааврыг боловсруулан зах зээлд нэвтрүүлэх;
- Ханшийн эрсдэлээс сэргийлэх санхүүгийн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх, своп, форвард хэлцлийн захыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

◇ Арилжааны банкууд:

- Санхүүгийн үүсмэл хэрэгсэл, своп, форвард хэлцлийн хэрэглээний талаарх сургалтыг харилцагч аж ахуйн нэгж байгууллагад тогтмол зохион байгуулах;
- Банк хооронд болон харилцагч аж ахуйн нэгж байгууллагуудтай хийх валютын своп, форвард хэлцлийг нэмэгдүүлэх;
- Банк хоорондын арилжааг нэмэгдүүлж, арилжааны ханш солилцох, арилжаа хийх үйл ажиллагааг тогтмолжуулах.

◇ Аж ахуйн нэгж, байгууллагууд:

- Бизнесийн эрсдэлийн нэг хэсэг болох ханшийн эрсдэлээ зөв удирдахад суралцан, харилцагч банкуудтай идэвхитэй хамтарч ажиллах.

Корпорейт ресорт
Нүхт цогцолбор
Улаанбаатар хот
Монгол Улс



Бага тойруу 3, 15160.
Улаанбаатар, Монгол

Утас: 976-11-324149

Факс: 976-11-311471
www.mongolbank.mn